

2019 ОНД ИТХ ТҮҮНИЙ ТЭРГҮҮЛЭГЧДЭЭС ЗОХИОН БАЙГУУЛСАН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019.12.25

Алтраг

Баянзүрх сумын ИТХ, түүний Тэргүүлэгчдээс 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг 2019.02.18-ны өдрийн Тэргүүлэгчдийн хуралдааны 03 тоот тогтоолын 1-р хавсралтаар 5 бүлэг 60 зүйлтэй баталж хэрэгжилт 90%, тус тогтоолын 2-р хавсралтаар батлагдсан ИТХ-н ажлын албанаас сар бүр хэрэгжүүлэх 13 ажлын график төлөвлөгөө 92.3%-ийн биелэлттэй хэрэгжлээ. Мөн ажлын төлөвлөгөөнд тусаагүй 4 бүтээлч ажил өрнүүлж, үүнээс олон нийтийг хамарсан 1, хяналт шалгалтын чиглэлээр 3 ажил зохион байгуулав.

1. Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах
2. Сар шинийн баяр, Ахмадын баярыг тохиолдуулан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ
3. ОУ-ын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ИТХ-д ажиллаж байсан үе үеийн эмэгтэй төлөөлөгчдөд хүндэтгэл үзүүлэх
4. Төрийн албан хаагчдын дунд хууль, эрх зүйн олимпиад зохион байгуулах
5. Байгаль орчны ГХУС ажил өрнүүлэх, “МИНИ-ИТХ”-тай байгаль орчинд ээлтэй арга хэмжээ зохион байгуулах
6. ОУ-ын УЗН-ийн өдрийг тохиолдуулан өдөрлөг зохион байгуулах
7. Эх үрсийн баярын өдрийг тохиолдуулан “Алдарт эх”-ийн одон гардуулах үйл ажиллагаа зохион байгуулах
8. Эмэгтэйчүүд, охидод зориулсан өдөрлөг зохион байгуулах
9. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тохиолдуулан олон төрөлт арга хэмжээ зохиох
10. Ахмадын өдрийг тохиолдуулан ахмад настны тухай хууль, төрөөс ахмадуудад үзүүлж буй үйлчилгээг сурталчлан таниулах, арга хэмжээ зохион байгуулах
11. Их эзэн Чингис хааны өдөр, Улс тунхагласны баярын өдрийг тохиолдуулан олон төрөлт арга хэмжээ зохион байгуулах
12. Монгол бахархал, ёс заншлыг сурталчлан таниулах үйл ажиллагаа зохион байгуулах
13. Шилдэг аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг шалгаруулах арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөжээ. Тус ажлуудыг тус бүрээр нь тайлагнавал:

I. Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 27 жилийн ойн арга хэмжээний хүрээнд тус сумын ИТХ, ЗДТГ-аас Үндэсний бөхийн барилдаан, АИХ-ын депутат Л.Батчулууны нэрэмжит шилдэг БАГ шалгаруулах шатрын тэмцээнийг тус тус зохион байгууллаа.

Үндэсний бөхийн барилдаанд с/з Т.Баасан-Очир түрүүлж, с/з Б.Хадбаатар үзүүрлэн, с/з Б.Батбаясгалан, с/н Б.Уламдэлгэр нар шөвгөрлөө. Мөн цолгүй залуу бөхчүүдийн барилдаанд Эмт багийн залуу бөх Т.Батбямба түрүүлж, Хайс багийн Э.Батбаяр 2-р байр, Тоом багийн Г.Тулгаа 3-р байр, Хайс багийн Г.Пүрэвхишиг 4-р байр, Н.Шинэбаяр 5-р байр, П.Цэрэнчимэд 6-р байрт тус тус шалгарсан байна.

АИХ-ын 380- р тойргийн депутат Л.Батчулууны нэрэмжит шатрын тэмцээнд нийт 85 тамирчид оролцож,

• **Насанд хүрэгчид /эр/**

1. Б.Баярмагнай
2. Д.Мөнхбат
3. Б.Сэргэлэнбаяр

• **13- 18 нас /эр/**

1. Г.Одхүү
2. Б.Сүх-Эрдэнэ
3. Б.Сүхболд

• **6-12 нас /эр/**

1. Б.Пүрэвбаяр
2. Б.Гантогтох
3. О.Мөнгөнцоож

өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулав.

Багийн нийлбэр дүнгээр ТЭРГҮҮН байранд Э.Ганзориг даргатай Тоом 3-р баг шалгарч ЦОМ, мөнгөн шагнал, ДЭД байранд Ц.Хишигбаяр даргатай Бэлтэс 5-р багийн хамт олон шалгарлаа.

/эм/

1. Б.Мөнх-Эрдэнэ
2. Т.Солонго
3. Х.Адилзаяа

/эм/

1. Б.Хулан
2. Т.Хишигбуян
3. Б.Энхдалай

/эм/

1. Б.Бүжинлхам
2. Г.Номин-Эрдэнэ
3. Д.Одончанцал нар шалгарч медаль,



Зураг 1: Үндэсний бөхийн барилдаанд шөвгөрсөн бөхчүүд



Зураг2: Шатрын тэмцээний “Шилдэг баг”

II. Сар шинийн баяр, Ахмадын баярыг тохиолдуулан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ

17 дугаар жарны "Урвуулагч" хэмээх шороон гахай жилийн хаврын тэргүүн сарын шинийн 8-ны билэгт сайн өдрийг тохиолдуулан Баянзүрх сумын "Ахмадын золголт-2019", буддын шашны дээдийн ном хуруулах, зул өргөх хүндэтгэлийн үйл ажиллагааг ИТХ, ЗДТГ-ын зүгээс зохион байгуулав.

Дээдийн ном хурах үйл ажиллагаанд Хөвсгөл аймгийн сүсэгтэний холбооны тэргүүн Жалбаажамц, Цэцэн хүрээ, Дашчойлон хийдийн унзад Баасандорж, лам Батбаяр, Галбаабадраа нар урилгаар оролцож, буяны ном хурж, зул өргөв.

"Ахмадын золголт-2019" арга хэмжээг өргөн дэлгэр явуулж, баг байгууллагууд ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн нь тэдний талархлыг ихэд хүлээлээ. Уг үйл ажиллагааны үеэр тус сумын өндөр настан Дэмбэрэлийн Андрей төрийн дээд шагнал "Алтан гадас одон"-оор энгэрээ мялаалаа. Мөн сар шинийн барилдааны үндэсний бөхийн барилдаанд с/з Б.Батбаясгалан түрүүлж, с/з Т.Баасан-Очир үзүүрлэж, с/н Б.Эрболд, с/з Э.Ганзориг нар шөвгөрлөө.

Цолгүй залуу бөхчүүдийн барилдаанд Т.Батбямба 15-н даваагаар түрүүлж, 2-р багийн Батбаяр 11-н даваагаар 2-т, 3-р багийн Баттулга 11н даваагаар 3-т, 2-р

багийн Г.Пүрэвхишиг 11-н даваагаар 4-т, 2-р багийн Н.Шинэбаяр, 3-р багийн П.Цэрэнчимэд нар 5,6-р байр эзлэв.

Түүрү бөхийн шагналд Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч Галсангийн Батцогт 200,000 төгрөг, сумын Үндэсний бөхийн холбоо 2-10 дугаар байранд шалгарсан бөхчүүдэд нийт 480,000 төгрөгийн бай шагнал олгосон байна. Барилдааны үеэр 10 азтай үзэгчид 100,000 төгрөг, 2 азтанд 25 кг гурил, супер азтанд тавгийн идээ олголоо.

Мөн Сумын ИТХ, "Уул-Ухаан" ТББ-ын хамтын ажиллагааны хүрээнд тус байгууллагын тэргүүн, АНУ-ын Монтаногийн Их Сургуулийн багш Д.Бадмаа, З.Бат-Эрдэнэ нарын 10 өрхөд олгосон гарын бэлэг, сар шинийн мэндчилгээг хүргэлээ.

"Уул-Ухаан" ТББ-ын гарын бэлгийг:

- Д.Баасанчулуу - Эмт баг
- Ш.Баасандолгор - Эмт баг
- А.Оюун - Тоом баг
- Д.Сарантуяа - Тоом баг
- Д.Отгонцэцэг - Хайс баг
- Д.Амгалан - Хайс баг
- Г.Буяндалай - Бэлтэс баг
- Т.Цолмон - Бэлтэс баг нарт олгов.



Зураг 3,4: Сар шинийн баярын үйл ажиллагааны үеэр



Зураг 5,6: Сар шинийн баярын үеэр ахмадуудад хүндэтгэл

үзүүлэх үйл ажиллагаа



Зураг 6,7: ИТХ, “Уул ухаан” ТББ-ын хамтын ажиллагааны хүрээнд тус сумын 8-н өрх толгойлсон эмэгтэйд өргөн хэрэглээний бараа олгов.

III. ОУ-ын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ИТХ-д ажиллаж байсан үе үеийн эмэгтэй төлөөлөгчдөд хүндэтгэл үзүүлэх

ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тус суманд өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлж байна. 3 сарын 07-ны өдөр НАМЭХ-оос ӨРГӨМЖИТ ЭЭЖүүдийг шалгаруулах баярын үйл ажиллагаа зохиосон бол 3 сарын 08-ны өдөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Эмэгтэйчүүдийн холбооноос "ЭЭЖ БАХАРХАЛ" хүндэтгэлийн арга хэмжээ явуулж, үе үеийн төлөөлөгч эмэгтэйчүүдээ хүндэтгэл үзүүллээ. Тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 1995-2016 оны ээлжит сонгуулийн дүнгээр П.Нансалмаа, Б.Энхжаргал, Н.Хүүхэнжий, Б.Энхтайван, Л.Бямбасүрэн, П.Энхтуяа, Ц.Бузмаа, Н.Баасанжав, Т.Мөнхцэцэг, Ш.Агар, Д.Мандах, Н.Долгорсүрэн, Р.Цэрмаа, Б.Хишигжаргал, М.Баасанжав нарын 15 эмэгтэй сумын ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдож байжээ. Цаашид Нутгийн Өөрөө Удирдах ёсны байгууллагатай ажил, амьдралаа холбосон нийт эмэгтэйчүүдээ хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг өргөжүүлж, уламжлал болгон зохион байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Энэ үеэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч Пүрэвийн ЭНХТУЯА төрийн дээд шагнал "Хөдөлмөрийн хүндэт медаль"-иар энгэрээ мялаалаа.



Зураг 8,9: Үе үеийн эмэгтэй төлөөлөгчдөд хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааны үеэр

IV. Төрийн албан хаагчдын дунд хууль, эрх зүйн анхдугаар олимпиад зохион байгуулав

Олон нийтийн оролцоонд тулгуурлан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиудыг судлах аян өрнүүлэх ажлын хүрээнд иргэд, төрийн албан хаагчдын дунд уг олимпиадыг 2 үе шаттайгаар зохион байгууллаа. 1-р үе шатанд байгууллага дотроо олимпиад зохион байгуулж, шалгарсан 5 албан хаагч 2-р шатны олимпиадад оролцож хувийн дүнгээр

1-р байр – З.Наранцэцэг /ЗДТГ/

2-р байр – Г.Чимэд-Аюуш /ЗДТГ/

3-р байр – М.Баттулга /ЗДТГ/

4-р байр – Б.Мөнхбат /ЕБС/

5-р байр – Н.Наранхүү /Агар баг/ нар тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулав.



Зураг 10: Хууль, эрхзүйн анхдугаар олимпиадын үеэр

V. Байгаль орчны ГХУС ажил өрнүүлэх, “МИНИ-ИТХ”-тай байгаль орчинд ээлтэй арга хэмжээ зохион байгуулах

“Эцэг эхэд хүргэх захидал” аяны хүрээнд ойн түймэр гарах эрсдэлтэй, загас болон бусад ан амьтдын үржлийн үе тохиож буйтай холбогдуулан ЕБС-ийн 6 ангийн 120 хүүхдэд хүүхэд хамгаалал, байгаль орчноо хамгаалах, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлийн брошуртай дугуйт захидлыг “МИНИ-ИТХ”-тай хамтран хүргүүллээ. Мөн БОТХБТ-тай хамтран ГХУСА33-өөс 200 өрхөд Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, галын аюулгүй байдлыг хангах болон байгаль орчныг хамгаалах талаар иргэдийн үүргийн талаар хууль сурталчлах, таниулах хуудас бүхий, албан байгууллага, өрхийн утасны жагсаалттай гарын авлага тараав.



Зураг 11: БО-оо хайрлан хамгаалах талаар эцэг, эхэд хүргэх захидал болон тараах материал

VI. Эх үрсийн баярын өдрийг тохиолдуулан “Алдарт эх”-ийн одон гардуулах үйл ажиллагаа зохион байгуулах

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 98 дугаар зарлигаар тус сумаас "Эхийн алдар одон-2"-оор дараах 9 эх шагнагдлаа.

2019 онд Басдарь БОЛОРТУНГАЛАГ, Бадам БАЯНМӨНХ, Пүрэвдорж БЯМБАА, Гунгаа ДОЛГОРМАА, Андрей ДЭЛГЭРМАА, Андрей ӨНӨРЖАРГАЛ, Жүгдэрбямба САРАН, Шарав САРНАЙ, Болд ШИНЭБАЯР нарын эхчүүд “Эхийн алдар-2” одонгоор шагнагдлаа. Тус эхчүүдэд төрийн дээд одон гардуулах ёслолын үйл ажиллагааг ОУ-ын Хүүхдийн баярыг тохиолдуулан сумын нийт эмэгтэйчүүд, хүүхдүүдэд зориулан баярын арга хэмжээтэй хамтатган зохион байгууллаа.



Зураг 12: “Эхийн алдар-2” одон гардуулах ёслолын үйл ажиллагааны үеэр

VII. Эмэгтэйчүүд, охидод зориулсан өдөрлөг зохион байгуулах

2012 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас жил бүрийн 10 дугаар сарын 11-ний өдрийг олон улсын охидын өдөр буюу охидын эрхийг хамгаалах олон улсын өдөр болгон зарласан.

Энэхүү өдрийг жил бүр дэлхий нийтээр тодорхой уриалга чиглэлийн дор тэмдэглэн өнгөрүүлдэг бөгөөд энэ жил “Охидын хүч тасралтгүй үргэлжилсээр” уриатайгаар 7 дахь жилдээ тэмдэглэгдэж байна. Тус өдрийг тохиолдуулан сумын ИТХ, Эрүүл мэндийн төв, Ерөнхий Боловсролын Сургуулийн захиргаа хамтран "Охид бүхэн

хөөрхөн" арга хэмжээг 10 сарын 10-ны өдөр зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 6-12 дугаар ангийн 176 охид сургалт мэдээлэл, хэлэлцүүлэгт хамрагдлаа.

- ИТХ-ын нарийн бичгийн дарга Х.Адилмаа - "Охидын эрхээ хамгаалах арга зам" "108 утасны ач холбогдол"
- ЭМТ, ЕБС-ийн эмч Л.Дэлгэрмөрөн, П.Даваадэлгэр нар - "Охидын эрүүл мэнд"
- ЭМТ-ийн нийгмийн ажилтан П.Энхтуяа - "Дүүлэн нис охид минь", Охидын тулгамдсан асуудал
- ЕБС-ийн багш О.Гарамлхамжав болон Охидын зөвлөлийн багш нар тус бүр сургалт мэдээлэл хийлээ.

"Охидын тулгамдсан асуудал" сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулж, шийдвэр гаргагчид, ЕБС-ийн захиргаанд хандаж уриалга гаргав. Хэлэлцүүлгээс гарсан саналууд:

Нэг: Сум орон нутгийн удирдлагуудад

1. Гудамж талбай төдийгүй, гэр бүлийн орчны архидалт, хүчирхийлэл, согтуугаар техник хэрэгсэл жолоодох гээд олон эрсдэлүүд тулгарч байна. Иймд энэ талын хууль эрхзүйн олон талт арга хэмжээг авч ажиллах
2. Сум орон нутгийн хэмжээнд нийтийн халуун усыг ажиллуулах
3. Сумын төвийн гэрэлтүүлэг, гудамж талбайн өнгө үзэмжийг сайжруулах

Хоёр: ЕБС-ын сургуулийн захиргаанд

1. Сургууль анги танхимын дулаан халаалтыг сайжруулах
2. ОО-ын хүрэлцээг нэмэгдүүлэх, бохирыг цэвэрлэж байх
3. Дугуйлан секц хичээллүүлэх, хүмүүжлийн ажил зохион явуулдаг байх
4. Сургуульд сэтгэл зүйч ажиллуулах
5. Сургууль дээр охидын өрөөг байгуулж, тохижуулж өгөх
6. Илтгэл мэтгэлцээний клуб, энэ талын багшийг урьж ажиллуулах
7. Биеийн тамирын хичээлийг чанартай оруулдаг байх, дэмий шуугиж байгаад гарч ирдэг

Гурав: Сургуулийн эмч, эрүүл мэндийн албанд

1. Охидын эрүүл мэндийн үзлэг хийх үед орчныг сайжруулах, /хаалт халхавч, өрөөний аюулгүй орчныг бүрдүүлэх гэх мэт /
2. Эрүүл мэндийн нээлттэй өдөрлөг арга хэмжээг сургууль дээр зохион явуулдаг байх
3. Сургуулийн дотуур байрны орчны эрүүл ахуйг сайжруулах, ээлтэй орчныг бүрдүүлэх зэрэг саналууд гаргаж холбогдох албан тушаалтанд хүргэж ажиллав.



Зураг 13: Охидын өдөр"-т зориулсан сургалт, арга хэмжээний үеэр

VIII. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тохиолдуулан олон төрөлт арга хэмжээ зохион байгуулав

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр жил бүрийн 9 дүгээр сарын 10-ны өдөр тохиодог билээ. Энэ өдрийг тохиолдуулан ИТХ-ын ажлын албанаас 4 төрлийн арга хэмжээ зохион байгууллаа. ЕБС-ийн 10, 11 дүгээр ангид "Мартах эрхгүй, давтах ёсгүй түүх" сэдэвт хичээл орж, 80 сурагчид брошур тарааж өгөв. Мөн 6-9 дүгээр ангийн сурагчдын дунд "Хэлмэгдэгсэд" гар зургийн уралдаан зарласны дагуу 56 сурагч бүтээлээ ирүүлж


1-р байр - Д.Өлзий-Очир /9б анги/

2-р байр - Б.Янжинлхам /6в анги/

3-р байр - Б.Хулан /9б анги/

Тусгай байр - Б.Золзаяа /7б анги/

Тусгай байр - М.Мөнхбат /6в анги/ нарын зураг шалгарлаа. Б.Батчулуун багштай 8а ангийн сурагчид хамгийн олон бүтээл ирүүлж "Манлайлагч хамт олон"-оор шалгарч, дурсгалын зүйлээр шагнуулав. Тус уралдаанд Ц.Өнөржаргал багштай 6в анги, Н.Мягмарсүрэн багштай 6а анги, Б.Цэрэнлхам багштай 9б анги, Б.Долгормаа багштай 7б анги, Л.Батчулуун багштай 8а анги идэвхтэй оролцов. М.Олзхүү багштай 10а анги, Т.Жавзандулам багштай 11а ангид "Мартах эрхгүй, давтах ёсгүй түүх" сэдэвт хичээл орлоо. Мөн хэлмэгдэгсдийн ар гэрийн дурсамж яриаг цувралаар хүргэж ажиллалаа.



Зураг 14: “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр”-ийн үеэр

IX. Ахмадын өдрийг тохиолдуулан ахмад настны тухай хууль, төрөөс ахмадуудад үзүүлж буй үйлчилгээг сурталчлан таниулах, арга хэмжээ зохион байгуулах

1990 оны 12 дугаар сарын 14-ний НҮБ-ын Ерөнхий Ассамблейн шийдвэрээр Олон улсын ахмадын өдрийг 10 дугаар сарын 01-нд тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлал тогтоод 29 жил болж буй бөгөөд манай улс тус өдрийг 1992 оноос тэмдэглэн өнгөрүүлдэг болжээ.

Баянзүрх сум нь тэтгэврийн насны 378 ахмадтай. Ахмадын өдрийг тохиолдуулан ИТХ, ЗДТГ, Ахмадын хорооноос олон төрөлт арга хэмжээ зохион байгуулж, өргөн хүрээнд тэмдэглэн өнгөрүүллээ. Мөн аймгийн ИТХ-ын төлөөлөгч Г.Батцогт хагас сая төгрөг, аймгийн Засаг дарга Л.Ганболд 250 ахмадад гарын бэлэг гардуулав.

Ахмадын хүндэт тэмдэгээр Лутын Нямдорж, Ахмадын хорооны баярын бичгээр С.Дарьсүрэн, Д.Даваажий, сумын Ахмадын хорооны шагналаар Ч.Бумаа, С.Эрдэнэчимэг, Г.Өнөржаргал нар шагнууллаа.

"Баялаг бүтээгч ахмад" үзэсгэлэн худалдаа зохион байгуулж цагаан идээ, жимс жимсгэнэ, оёдол, бусад гэсэн төрлөөр шалгаруулж байр эзлүүлэв. Мөн ширээний теннис, софт волейбол, гүйлт зэрэг спортын тэмцээн, дуу, бүжиг, хөзөр, даалууны тэмцээнийг нэмэлтээр зохион байгууллаа.



Зураг 15,16: Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааны үеэр

Х. Улс тунхагласны баяр, Монгол бахархалын өдрийг тохиолдуулан зохион байгуулсан үйл ажиллагаа

Бүгд Найрамдах улсаа тунхаглаж, Анхдугаар Үндсэн хуулиа баталсаны 95 жилийн ойн өдрийг тохиолдуулан тус суманд Үндэсний бөхийн барилдаан, 100 буудалт даамны САШ тэмцээн зохион байгуулагдлаа. Үндэсний бөхийн барилдаанд 1 давсан 10 бөхийг тойргийн журмаар барилдуулж с/з Т.Баасан-Очир түрүүлж, с/з А.Буяннэмэх үзүүрлэв.

3. с/н Т.Батбямба

4. с/н Б.Энхтөр

5. с/з Д.Батбямба

6. с/н Г.Баттулга

7. с/х Т.Мөнхсайхан

8. с/н Б.Бямбабаяр

9. с/н Б.Эрболд

10. Б.Мягмардорж /залуу бөх/ нар амжилтын жагсаалтаар байр эзэллээ.

100 буудалт даамны насанд хүрэгчдийн аварга шалгаруулах тэмцээнд 22 тамирчин оролцож /эр/

1. М.Давааням /Тоом баг/

2. Б.Сэргэлэнбаяр /ЕБС /

3. Н.Мягмарсүрэн /ЕБС/

/эм/

1. Ц.Отгончимэг /ЕБС/

2. Р.Цэрмаа /Бэлтэс баг/

3. Т.Солонго /Эмт баг/ нар тус тус байр эзэлж медаль, мөнгөн шагналаар шагнуулав.

Мөн 11 дүгээр сарын 25-ны өдөр Үндэсний хувцасаараа гоёх өдөр болж ЕБС, СӨББ-ын сурагчид идэвхтэй оролцов.



Зураг 17,18: Монгол бахархалын өдөр зохион байгуулагдсан арга хэмжээний үеэр

XI. “ТӨЛӨӨЛӨГЧИЙН ӨДӨР” АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Баянзүрх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Төлөөлөгчийн өдөр” арга хэмжээ 2019 оны 10 сарын 18-ны өдөр зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээний үеэр:

1. ИТХ-ын ээлжит бус XIV хуралдаан хуралдаж - Хуралдаанаар Багийн хилийн цэс тогтоох, 2019 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх зарим ажлын нэршил, зориулалт өөрчлөх асуудлыг хэлэлцлээ.
2. “Тогтоол танилцуулах аян”- 21 төлөөлөгч болон иргэд, албан байгууллагуудад 2019 оны Тэргүүлэгчдийн хагас жилийн тогтоолын эмхтгэл, танилцуулага тарааж байна.
3. “Миний мэдэх Төлөөлөгч”эссэ бичлэгийн уралдаан явагдаж- Тус эссэ бичлэг шүлгийн уралдаанд ЕБС-ийн 9-12 дугаар ангийн 22 сурагч оролцож 1-р байр Д.Дэжидмаа, 2-р байр Б.Дуламсүрэн, 3-р байр Г.Энхтуул нар шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулав.
4. Бүтээлч ажлын хүрээнд Суурьтын дөрөлжний зам засах ажилд ИТХ, ЗДТГ болон цэргийн дүйцүүлэх албаны 4 залуу хамрагдаж үерт идэгдэж эвдэрсэн гуу жалгыг засварлаж тээврийн хэрэгсэл аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэв.

"Төлөөлөгчийн өдөр-2019" үдэшлэг арга хэмжээний үеэр тус сумын албан байгууллагууд ИТХ-ын хамт олонд мэндчилгээ дэвшүүлж гарын бэлэг гардуулан өглөө. ЕБС-ийн хамт олон ИТХ-ын төлөөлөгч нарт "Оюунлаг Хөвсгөлчүүд" энгэрийн тэмдэг гардуулсан болон СӨББ-ын хамт олны мэндчилгээ үдэшлэг, цэнгүүний онцлох үйл явдал байлаа. Мөн Баянзүрх сумын Засаг дарга Б.Баярмагнай, Санхүү албаны дарга А.Дэлгэрмаа нар аймгийн ИТХ-ын "Баярын бичиг"-ээр шагнуулж, УИХ-ын гишүүн Л.Мөнхбаатар төлөөлөгч нарт гарын бэлэг хүргүүлсэнийг гардуулж өглөө.

Төлөөлөгчийн өдрийн арга хэмжээ зохион байгуулсан нь НӨУЁБ болон төрийн албан байгууллагуудын нөхөрсөг харилцааг үүсгэн ИТХ-ын үйл ажиллагаа, тогтоол шийдвэрээ олон нийтэд сурталчилсан үр дүнтэй ажил байв.

Тус арга хэмжээг үр дүнтэй болгож хамтран ажилласан ЗДТГазар, ЕБС, СӨББ, Дүйцүүлэх албаны залуучуудад гүн талархал илэрхийлж, ажлын өндөр дээд амжилт хүсье.



Зураг 19:20- “Төлөөлөгчийн өдөр” арга хэмжээний үеэр



Зураг 21:22: Суурьтын дөрөлжний зам өмнөх болон зассаны дараах байдал

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД:

2019 онд ИТХ-ын ажлын албаны зүгээс ЗДТГ-ын мэргэжилтэн, зарим төлөөлөгч, Тэргүүлэгчидтэй хамтран 4 төрлийн хяналт шалгалтын ажил өрнүүллээ.

5. Үдийн цай хөтөлбөр, гал тогооны стандартын хэрэгжилт
6. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа
7. Шилэн дансны хэрэгжилт
8. ОНХС-ийн үйл ажиллагаа

1. Үдийн цай хөтөлбөр, гал тогооны эрүүл ахуй, стандарт:

ИТХ-ын даргын 2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн “Баянзүрх сумын ЕБС, Хүүхдийн цэцэрлэгийн гал тогоо, “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилт буюу гал тогооны стандартад хяналт хийх ажлын удирдамж”-ийн дагуу 2019 оны 09 сарын 12-ны өдөр дээрх байгууллагуудын гал тогоо, “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжүүлэгч компаний үйл ажиллагаатай танилцав.

Хяналт шалгалтын бүрэлдэхүүнд:

1. Д.Нямдэлгэр – ИТХ-ын дарга
2. Х.Адилмаа – ИТХ-ын нарийн бичгийн дарга
3. Б.Батбаяр – Засаг даргын орлогч
4. П.Энхтуяа – ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч
5. Ш.Агар – БИНХ-ын дарга
6. З.Наранцэцэг – Хүнс, ЖДҮ хариуцсан мэргэжилтэн нар ажиллаж, ЕБС-ийн захирал М.Санжаа, Нийгмийн ажилтан Г.Батсанаа, ЕБС-ийн эмч Б.Даваадэлгэр, нярав Б.Мөнхбат нар хамтран оролцов.

Хяналт хийх ажлыг дараах асуулгын дагуу явуулж, оноогоор дүгнэлээ.

№	Хяналт шалгалтын асуулт	Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй	Зарим нь шаардлага хангасан
1	Дээжний бүртгэл хөтлөлт /Нэг удаад бэлтгэсэн хоол, хүнснээс 150 граас доошгүй хэмжээгээр дээж авч +4 өөс+8 хэмд 48-72 цаг хадгалдаг, бүртгэлийг тогтмол хөтөлдөг/	5	0	2.5
2	Ус хадгалах савны зориулалт	5	0	2.5
3	Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан эсэх	5	0	2.5
4	Гар угаах зааварчилгаа гаргах, угаалтуур	5	0	2.5
5	Хөдөлмөр хамгааллын хувцастэй эсэх /Ажиллагсад ажлын байранд ээмэг, бөгж, зүүлт, бугуйн цаг, гарын хумс ургуулж будаагүй, гарын ариун цэврийг сахидаг эдгээрт хяналт тавьж бүртгэл хөтөлдөг, халад, гутал, хормогч, бээлий, үсийг бүрэн халхлахуйц толгойны өмсгөл зэрэг хувцсаар бүрэн хангагдсан, хэрэглэдэг, цэвэрхэн өнгө алдаагүй, 2-оос доошгүй ээлжийн хувцастай/	5	0	2.5
6	Мах, ногооны вандан, тавиур тус тусдаа, зориулалтын ууттай байх	5	0	2.5
7	Санал хүсэлтийн дэвтэртэй байх	5	0	2.5
8	Зааварчилгааны дэвтэртэй байх	5	0	2.5
9	Ялаа устгал хийх	5	0	2.5
10	Ариутгалын бодисын хэрэглээ	5	0	2.5
11	Дамжлагат угаалгыг зааврын дагуу байрлуулсан эсэх	5	0	2.5
12	Ажлын байрны өдөр тутмын угаалга, цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг графикийн дагуу тогтмол хийдэг, бүртгэл хөтөлдөг	5	0	2.5
13	Мэргэжлийн тогоочтой /Мэргэжил дээшлүүлэн давтан сургалт явуулах тусгай хөтөлбөртэй, ажиллагсдыг сургалтад хамруулдаг, бүртгэлтэй/	5	0	2.5

14	Хоол амталгааны өдөртэй, тогтмол хэрэгжүүлдэг бүртгэл хөтөлдөг эсэх	5	0	2.5
15	Нийт оноо			

Дээрх 14 асуултын дагуу нэгбүрчлэн танилцсан дүгнэлтээ сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж холбогдох байгуулагуудад зөвлөмж хүргүүлэх юм.

Доорх хүснэгтийн дагуу “Үдийн цай” хэрэглэгч 1-5 дугаар ангийн сурагчид, багш, эцэг эхчүүд нийлсэн 179 хүнээс сэтгэл ханамжийн судалгаа авч, дүнг нэгтгэлээ.

Баянзүрх сумын
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

**“ҮДИЙН ЦАЙ” ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН
СУДАЛГАА**


/Уг судалгаанд та өөрийн мэдээллийг бичих шаардлаггүй тул үнэн зөв хариулт өгөхийг хүсье!
/Сонгосон хариултньгаа бор “+” тэмдэг тавьна уу!


№	Асуулга	Сайн	Сайжирч байна	Дунд	Анхаарах хэрэгтэй	Тааруу
1	Хоолны амт	+				
2	Хоолны чанар		+			
3	Хоолны хэмжээ /порц/	+				

Танд өөр санал хүсэлт байна уу?
Олон өөр төрлийн хоол

2019.09.05

Зураг 1: “Үдийн цай” хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны хуудас





Судалгаанд оролцогчид хоолны амтанд сэтгэл хангалуун байх бөгөөд хоолны хэмжээ, чанарт анхаарах хэрэгтэй байгаа гэж хариулжээ.

Мөн **Танд өөр санал хүсэлт байна уу?** гэх нээлттэй асуултад:

- ✚ Хоолны нэр төрлийг олшруулах
- ✚ Цагтаа хоолоо өгөх
- ✚ Тогооч нарын ур чадвар сайжруулах
- ✚ Удирдлага болон захиалагчаас хяналт сайн тавих зэрэг асуудлыг голчлон бичсэн байна.

Дотуур байранд амьдардаг 6-аас дээш ангийн сурагчдаас дээрх төрлийн судалгааг үргэлжлүүлэн авч байна.

Дүгнэлт

Судалгаанаас үзэхэд “Үдийн цай”-ны амт сайн, чанар дунд зэрэг, хоолны порц /хэмжээ/ тааруу гэх дүгнэлт гарав. Мөн дараах нийтлэг зөрчлүүд байна.

1. “Үдийн цай” гүйцэтгэгч компаний орон тоо цөөн, цагаа барьдаггүй, хичээл тарж байхад ирдэг. Сүүлийн ангиудад хоол, цай хөрсөн ирдэг.
2. Хоолны цэс, орц, нормыг батлуулаагүй
3. Дээжийн бүртгэлийг тухай бүр авч, тэмдэглэгээ хийж зориулалтын дагуу хадгалаагүй
4. Анги удирдсан багш нарт хоолны батлагдсан цэсээ өгөөгүй
5. “Үдийн цай” хэрэгжүүлэгч орчны хувьд усны саваа цэвэрлэдэг бүртгэл байхгүй, усны сав ариутгах, зааварчилгааны болон хяналт үнэлгээний дэвтэр байхгүй, тогооч нарыг ХЭА-н сургалтад хамруулж байх, усны саваа шинэчлэх, хөдөлмөр хамгааллын 2 ээлжийн хувцасгүй, мах ногооны тусдаа вандан тусдаа, ууттай болох, өдөр тутмын цэвэрлэгээний хуваарь гаргах зэрэг нийтлэг зөрчил илэрлээ.

ЕБС-ийн гал тогоонд:

1. Усны сав шаардлага хангахгүй олон жил болсон /МХГ-аас шаардлага өгсөн/
2. Дотуур байрны хүүхдийн хоолонд хэрэглэх 40 аягатай байсан нь 1 ээлжийн хоолонд ч хүрэлцэдгүй. Аяганы тоог яаралтай 160 ба түүнээс дээш болгох
3. Халбага, сэрээ мөн хүрэлцээ муутай.
4. ЕБС-ийн удирдлагаар хоолны цэсээ баталгаажуулж байх

СӨББ-ын гал тогоонд:

1. Хоолны цэсээ баталгаажуулж байх
2. Дээжний тэмдэглэгээ хийх, зориулалтын дагуу хадгалах, устгах
3. Мах, ногооны вандан ууттай байх
4. 3 дамжлагат аяга угаалтын болон гар угаах зааварчилгаатай байх
5. Усны сав цэвэрлэгээний бүртгэлтэй байх гэх мэт хяналт үнэлгээний хуудсанд заасан шаардлагуудыг бүрэн биелүүлэх шаардлагатай байна.



Зураг 21,22: ЕБС-ийн дотуур байрны хүүхдүүдийн хоолны газрын аяга хүрэлцээгүй, усны сав шаардлага хангаагүй, зарим цахилгааны утас гэмтэлтэй байсныг илрүүлж, албан тоот өгснөөр дээрх зөрчил арилсан болно.

2. ШИЛЭН ДАНСНЫ ХЭРЭГЖИЛТ:

Монгол Улсад Шилэн дансны тухай хууль 2014 онд батлагдаж 2015 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн билээ. Тус хууль батлагдсанаар улс, орон нутгийн төсөв, өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж буй эсэхэд иргэд хяналт тавьж, төсвийн удирдлагыг хэрэгжүүлж буй шийдвэртэй танилцах боломж бүрдсэн юм.





Шилэн дансны тухай хуулийн 8.1-д заасны дагуу бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх боломжтой. Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2019.09.16-нд тус сумын ИТХ-ын дарга "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын удирдамж" баталж төсвийн 6 байгууллагын дотоод хяналтын нэгж, байгууллагын удирдлагуудад сургалт мэдээлэл өгч, хяналтын ажил явууллаа.

Санхүүгийн албаны дарга А.Дэлгэрмаа, ЗДТГ-ын нягтлан бодогч М.Баасанжав нар "Шилэн дансны тухай", "Байгууллагын дотоод хяналтын нэгж" сургалт явуулж, ИТХ-ын нарийн бичгийн дарга нь байгууллагын дотоод хяналтын нэгжтэй хамтран төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн 6 байгууллагын шилэн дансанд оруулж буй мэдээлэлтэй танилцаж, хяналт хэрэгжүүлэв.

Зарим байгууллагууд мэдээллээ оруулсан боловч ойлгомжтой биш, мэдээллээ шинэчлээгүй, мэдээлэл хэвлэх боломжгүй, төсвийн зарлагын утга бүрэн бичээгүй зэрэг нийтлэг зөрчил ажиглагдав. Мөн Шилэн дансны тухай хуулийн 6.9, "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох тухай" ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолын 5.1-д заасны дагуу "Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн талаарх улирал бүрийн мэдээллийг дараа сарын 15-ны дотор маягтын дагуу цахимаар мэдээлэх" ёстой билээ. Одоогоор тус суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулаагүй байна. Тухайн хэрэгжүүлсэн хяналтын дагуу ИТХ-аас холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөмж хүргүүлээ.

Шилэн дансанд тавих хяналтыг доорх 10 үзүүлэлтийн дагуу хэрэгжүүлж дүгнэлт гаргалаа. /2019 оны байдлаар/

№	Байгууллагын нэр	Нийт оруулсан мэдээний тоо	Хугацаа хэтрүүлсэн мэдээний тоо	Гүйцэтгэлийн чанар %/	Авах ёстой оноо	Авсан оноо
1	Хөвсгөл аймаг Баянзүрх сум /Төсвийн ерөнхийлөн захирагч/	93	7	92,4%	7	7
2	ИТХ	97	12	87,6%	7	6
3	ЗДТГ	98	14	85,7%	7	5
4	ЕБС	91	23	74,7%	7	6
5	ЭМТ	95	28	70,5%	7	5,5
6	СӨББ	94	23	75,5%	7	5
7	Соёлын төв	94	23	75,5%	7	7



Зураг 23-26: : Шилэн дансны хэрэгжилтэнд хяналт тавих ажлын удирдамж, хяналтын хуудас, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, сургалтын PPT зураг

3. СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сум хөгжүүлэх сан гэж сум орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлээр дэмжих зорилгоор МУЗГ-ын 2011 оны 134 дүгээр тогтоолоор /уг тогтоол ЗГ-ын 2016 оны 153-р тогтоолоор хүчингүй болсон/ анх байгуулагдсан. 2011-2014 онд Улсын хэмжээнд нийт 84,0 тэрбум төгрөгийг улсын төсвөөс “Сум хөгжүүлэх санд” татан төвлөрүүлж 330 суманд хүн ам, эдийн засгийн боломжит нөхцөл байдлаас хамааруулж сумдад хуваарилалт хийжээ.

Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолын 3-р зүйлд заасны дагуу сумын ИТХ Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт тавин ажилладаг билээ. Баянзүрх сумын ИТХ-нь "Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт тавих орон тооны бус зөвлөл"-ийг 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 05 тоот тогтоолоор 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд хяналт тавих зөвлөлийн гишүүд, Төрийн сан, Жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн нарын хамтарсан бүрэлдэхүүн уг сангаас зээл авсан иргэдийн зээлийн, эргэн төлөлт, ашиглалт, зарцуулалт, тайлагналттай танилцаж, хяналтын үйл ажиллагааг 2019 оны 06,12 саруудад 2 удаа хэрэгжүүллээ.

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САН БАЯНЗҮРХ СУМАНД

2011-2019 онд нийт 95 иргэнд 764,3 сая төгрөг олгожээ. 2019 онд олгосон зээлээс 11 сарын байдлаар 13,2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл, 109,256 мянган төгрөгийн зээлийн алданги байгаагаас Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 1 зээлдэгчийн 189,888 мянган төгрөгийг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд 2 зээлдэгчийн 9,444,608 төгрөгийг эргэн төлүүлэхээр шилжүүлжээ. 2019 онд хугацаа хэтэрсэн зээлтэй зээлдэгчдэд 2-3 удаа хугацаатай мэдэгдэх хуудсыг хүргүүлж, өмнөх жилүүдтэй харьцуулахад хугацаа хэтэрсэн зээлийн дүн багассан байна.

ОН	ЗЭЭЛД ХАМРАГДСАН ААНЬ, ИРГЭД /тоо/	ОЛГОСОН ЗЭЭЛ	ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ
2011	10	62 сая	5,8 сая
2012	2	7,5 сая	23,2 сая
2013	25	169,0 сая	52,3 сая
2014	9	88,0 сая	84,0 сая
2015	6	76,8 сая	67,1 сая
2016	6	79,0 сая	76,9 сая
2017	8	67,0 сая	89,4 сая
2018	18	140,0 сая	107,7 сая
2019	11	75,0 сая	

Хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээг харуулвал:

Он	Хугацаа хэтэрсэн дүн сая.төг
2013	2,065 сая
2014	6,108 сая
2015	7,736 сая
2016	4,155 сая
2017	3,307 сая
2018	18,8 сая
2019	

2019 онд Сум хөгжүүлэх сангаас 75 сая төгрөгийг төсөл нь шалгарсан 11 иргэнд олгожээ.

№	Зээл авсан иргэд	Зээлийн хэмжээ	Зориулалт	Үйл ажиллагаа эхлүүлсэн эсэх
1	Б.Дулмаа	6,0 сая	Гутал засвар, оёх	Тийм
2	Г.Даваажав	4,0 сая	Арьс нэхий боловсруулах	Тийм
3	Х.Наранцэцэг	5,0 сая	Талх, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	Тийм
4	О.Агваандаш	13,0 сая	Авто угаалгын газар	Үгүй
5	Л.Дүүжий	5,0 сая	Малын эмийн сан ажиллуулах	Тийм
6	Б.Чинзориг	5,0 сая	Модон эдлэл, нарийн мужаан	Тийм
7	Б.Батбямба	3,0 сая	Гутал засвар	Тийм
8	Б.Бямбабаяр	13,0 сая	Авто засвар	Үгүй
9	Н.Энхтогтох	6,0 сая	Засварын үйлчилгээ	Тийм
10	Я.Бат-Эрдэнэ	5,0 сая	Талх, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Тийм
11	Ц.Өлзийдэлгэр	10,0 сая	Үслэг эдлэл боловсруулах	Үгүй

1. Сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэд, аж ахуйн нэгж байгууллага зээлээ зориулалтын дагуу ашиглаж буй эсэх

2019 онд зээл авсан 11 иргэний 8-нь зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулж, 3-нь үйл ажиллагаа эхлээгүй байна.

2. 2019 оны Зээлийн эргэн төлөлтийн хүү одоогоор 11 сарын байдлаар хэвийн төлөгдөж байна.



Дүгнэлт

1. 2011-2019 онд тус сумын 80 иргэнд 724,3 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч сумын бүтээн байгуулалтыг илэрхийлэх, тогтмол ажлын байрыг бий болгосон, үйл ажиллагаа нь тогтмолжсон ЖДҮ байхгүй байгаа нь тус сангийн хөрөнгийг үр дүнгээ өгөх, иргэдийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан, бодит хэрэгжих төсөлд өгөх тал дээр анхаарч ажиллах нь нэн тулгамдсан асуудал болжээ.
2. Цаашид сангийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод байлгахад анхаарч төсөл сонгон шалгаруулах чиглэл, хугацааг ард иргэдэд мэдээллийн олон суваг ашиглан хүргэх, төслийн тайлагналтыг тухай бүр авч байх
3. Төсөл сонгон шалгаруулахдаа төсөл хэрэгжүүлснээр бодитой үр дүн харуулж, үр нөлөөтэй байх эсэхэд дүн шинжилгээ хийж байх, төслөөс гарах бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн хэмжээ бага, өрсөлдөгч ихтэй чиглэлд зээл олгохдоо тухайн жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээний бусдаас ялгарах онцлог шинж чанар, мэдлэг туршлагыг харгалзан үйлдвэрлэл үйлчилгээгээ өргөжүүлэх зорилготой төсөлд зээл олгох
4. Сумын ИТХ-аар ЖДҮ-ийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тухай бүр батлуулж уг чиглэлд нийцүүлэн сонгон шалгаруулалтыг явуулах
5. Зээл авсан иргэдийн санал сэтгэгдэлийг асуухад анх төсөл бичихдээ тооцож оруулсан мөнгөн дүнгээсээ бага мөнгө авахад үйл ажиллагааны зардал дутагдаж байгаа гэж ярьж байх тул анхны төсөлд заасан мөнгөн дүнг нь сайтар нягталж, үйл ажиллагаа бүрэн эхлүүлэх боломжит хэмжээгээр олгох тал дээр анхаарах

4. ОНХС-ийн үйл ажиллагаа

Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС) нь нутгийн иргэдийн оролцоотойгоор тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэрэгсэл бөгөөд 2011 онд батлагдсан Төсвийн тухай хуульд тусгалаа олсон ба зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгддэг. Уг сангийн талаар Төсвийн тухай хуулийн 59, 60 дугаар зүйл болон Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан журмаар зохицуулж байна.

Манай суманд 2013-2018 онд нийт 641.603 сая төгрөгийн санхүүжилт ОНХС-

№	ОН	ТӨЛӨВЛӨСӨН	БОДИТ
1	2013	204,500 сая	173,377 сая
2	2014	279,921 сая	179,697 сая
3	2015	135,340 сая	108,610 сая
4	2016	85,777 сая	85,777 сая
5	2017	16,0 сая	11,348 сая
6	2018	82,803 сая	
7	2019	115,0 сая	

аас

олгогджээ.

/Баянзүрх суманд ОНХС-аас 2013-2018 онд төлөвлөсөн санхүүжилт/


ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг иргэдтэй хамтран төлөвлөж хэрэгжүүлдэг бөгөөд энэ үйл явцад баг, хорооны Засаг даргаас эхлээд баг, хорооны иргэдийн Нийтийн хурал болон бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурал хүртэлх бүх шатны байгууллагууд оролцон хамтын шийдвэр гаргадаг.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавих ажлын хэсгийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталж, тус ажлын хэсэг 2018 оны 11 дүгээр сард ОНХС-ийн төлөвлөлт, үр дүн нээлттэй байдлыг тандах чиглэлээр давхардсан тоогоор 121 иргэнээс судалгаа авлаа. Судалгааны асуулгыг 5-н үндсэн чиглэлээр боловсруулж, дүнг нэгтгэв.

СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН НАСНЫ БАЙДАЛ




1. ТА ОНХС-ИЙН ТАЛААР МЭДЭХ ҮҮ?



2. 2019 ОНД ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДЭХ АЖЛЫН САНАЛЫГ ТАНАЙ ӨРХӨӨС САНАЛЫН ХУУДСААР АВСАН УУ?



ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙГ ЯАЖ ХУВААРИЛАХ НЬ ЗӨВ БЭ?






Дүгнэлт

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын 12.2.1-д “Баг...-ийн Засаг дарга орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал арга замын талаар баг –ийн иргэдийн дунд нээлттэй санал асуулга явуулна” гэж зааж өгсөн. Судалгаанаас үзэхэд ОНХС-нд 7 жилийн хугацаанд 1 тэрбум орчим төгрөг төвлөрч сум орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд зарцуулагдсан байх ч судалгаанд оролцогсдын 50% нь уг сангийн талаар тодорхой ойлголтгүй, санал асуулгын хуудсаар санал аваагүй гэжээ. Иймд уг сангийн төлөвлөлтийг боловсронгуй болгоход иргэдийн оролцоог нэмэгдүүлэх олон талын арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй.

Мөн судалгаанд оролцогчдын 33% нь ОНХС-ийн хөрөнгийг нэг том бүтээн байгуулалтын ажилд, ажлын байр олноор бий болох ажилд зарцуулах нь зүйтэй гэснийг анхаарууштай.

ИТХ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУРТАЛЧИЛСАН БАЙДАЛ:

1. “Баянзүрхийн мэдээ” сонины шинэ дугаар 1000 ш хэвлүүлэв.
2. “Эрх чөлөө” сонины 2019 оны 10 сарын дугаарт ИТХ-ын 2019 оны үйл ажиллагааны мэдээ нийтлүүлэв.
3. <http://bayanzurkh.khovsgol.khural.mn/> сайтыг тогтмол ажиллуулж хандалтын тоог 25 мянгад хүргэв.
4. Тэргүүлэгчдийн 2019 оны тогтоолын эмхтгэл 100 ширхэг хэвлүүлж тараав.
5. ИТХ-ын төлөөлөгчдийн танилцуулгыг 1000ш хэвлэж тарааж байна.
6. Хөвсгөл аймаг Баянзүрх сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал цахим группыг тогтмол үр дүнтэй ажиллуулж, үйл ажиллагаагаа сурталчилан ажиллаж байна.



ИТХ-ын ажлын албанаас хэвлүүлсэн сонин, гарын авлагууд

ИТХ-ын байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

2019.04.09-ний өдрийн ИТХ-ын ээлжит бус 13-р хуралдааны 01 тоот тогтоолын 1-р хавсралтаар сумын давсан орлогоос ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгчдийн урамшуулалд 5,0 сая төгрөг батлуулж төлөөлөгч тус бүрт олгов. Мөн тус онд ИТХ-ын ажлын албанд Epson L3110 өнгөт принтер, ИТХ-ын хурлын даргын өрөөнд хуралдааны сандал 7 ш, 1 сейф, ИТХ-ын нарийн бичгийн даргад угтвар ширээтэй ажлын ширээ, сандалны /ком/ архивын үдээсний машин, таслагч, Асер загварын нөөтбүүк зэрэг техник хэрэгсэл, багаж төхөөрөмжийг 3,0 сая төгрөгөөр авав.



ДҮГНЭЛТ

Баянзүрх сумын ИТХ нь орон нутгийн ИТХ-ын ээлжит 7 дахь удаагийн сонгуулиар нутгийн ард иргэд, зон олныхоо итгэл хүндэтгэлийг хүлээн сонгогдож 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн бүрэн эрхээ хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Тухайн хугацаанд уламжлалаа хадгалж, шинэчлэлээ үргэлжлүүлэн хүн амынхаа боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулах замаар иргэдийнхээ сайн сайхан аж төрөх нөхцөлийг хангаж, боломжийг нээх улс орныхоо хөгжил дэвшилд оруулах хувь нэмрээ улам бүр нэмэгдүүлэх чиглэлээр орон нутгийн онцлог байдал, нутгийн иргэдийн санал хүсэлтийг харгалзан эрэлт хэрэгцээнд тулгуурласан төлөвлөгөөг боловсруулж, Монгол УИХ, ЗГ аймгийн ИТХ, ЗДТГ зэрэг удирдах дээд байгууллагаас гаргасан хөгжлийн хөтөлбөртэй нягт уялдуулан, үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ирлээ. Энэ хугацаанд тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүн Л.Мөнхбаатар түүний ажлын алба, аймгийн ИТХ, ЗДТГ, сумаас сонгогдсон аймгийн ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч Г.Батцогт нартай ажил хэргийн чиглэлээр байнгын харилцаа холбоотой ажилласнаар дараах хөрөнгө оруулалтыг татан оруулж бүтээн байгуулалтын бодит ажлуудыг хийж дуусган бүрэн ашиглалтад оруулаад байгаа нь Баянзүрх сум үүсгэн байгуулагдсан 86 жилийн түүхэн дэх 3 жилийн хугацаанд хийгдээгүй хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтууд байгаа нь тус сумын түүхэнд онцгойлон тэмдэглэгдэх ажил амжилтын 3 жил байлаа. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас

- 2017 онд 2012 оноос эхлэн 5 жил үргэлжилсэн 320 хүүхдийн хичээлийн байрны үлдэгдэл 800 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдэж, ашиглалтад оруулсан.
- 2017 онд байгаль цаг агаарын бэрхшээлтэй нөхцөлд НҮБ-ын хүмүүнлэгийн тусламжаар 118 малчин өрхөд 60 сая төгрөгийн тэжээл хувцас, хэрэглэл
- 2018 онд 150 хүүхдийн дотуур байрны санхүүжилт 1 тэрбум 720 сая төгрөгөөр үйл ажиллагаа эхлүүлж 2019 оны 11 сард ашиглалтад оруулсан.
- Link hands humanity ТББ-ын шугамаар сумын ЭМТ-д 65 сая төгрөгийн орчин үеийн эмнэлгийн тоног төхөөрөмж
- 2019 онд сумын ЗДТГ-ын барилга 1 тэрбум 240 сая төгрөгийн санхүүжилтээр тухайн онд багтаан 11 сарын 05-нд ашиглалтад хүлээн авсан.
- 2019 онд Агар багийн Хонин –Уулын заставын барилгыг 300 сая төгрөгөөр 2019 оны 11 сард ашиглалтад оруулсан.
- 2019 онд Агар , Хайс багуудын Юнителийн сүлжээний станцын өргөтгөл 150 сая төгрөгөөр үйл ажиллагааг нь эхлүүлсэн.
- ЕБС-ийн хичээлийн байрны ширээ сандал

- ЕБС-ийн дотуур байрны зөөлөн эдлэл 15 сая
- Эрүүл мэндийн төвд фургон автомашин 2016 оны 12 сард 25 сая төгрөгөөр
- 2017-2019 оны 3 иргэнд тус бүр нь 2,5 сая төгрөгийн үнэ бүхий гэр бүгд 7,5 сая
- 2019 онд нутгийн иргэдийн оролцоотой байгаль хамгаалах ОУ-ын ТНС төслийн хөрөнгө оруулалтаар ОУ-ын хүнсний стандартад нийцсэн бяслагны үйлдвэр 80,0 сая төгрөг зэрэг нийт 4 тэрбум 472 сая төгрөгийн хөрөнгө оруулалт мөн Аймгийн төсвөөс 2017 онд дотуур байрны засвар 85 сая, 2018 онд Эмт багийн төвийн барилгын засвар 20,0 сая төгрөг, хөдөөгийн 4 багийн Засаг дарга, хүний эмч нарыг бүрэн унаажуулж 8 мотоцикль , тус бүр 1,850,000 төгрөг, бүгд 9, 2019 онд Эмтийн зам, гүүр засварт 60,0 сая төгрөг, Эрүүл мэндийн төвд Мобайл зөөврийн оношлогооны аппарат 17 сая төгрөг зэрэг 191,400,000 төгрөг буюу нийт 4 тэрбум 663 сая 400 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж, үйл ажиллагаагаа явуулж үр дүнгээ өгч байна.

Мөн аймгийн ИТХ-ын төлөөлөгч , тэргүүлэгч Г.Батцогттой ажил хэргийн байнгын холбоотой ажиллаж, аймагт асуудал уламжлах, шийдвэрлэх талаар туйлын идэвх санаачлагатай ажиллахын зэрэгцээ Г.Батцогт нь 2019 онд Эмт 1-р баг, Тоом 3-р баг, Агар 4-р багийн хүний эмч нарын эмийн эргэлтийн санд 3,0 сая төгрөг, Хайс, Тоом, Эмт багуудад 4,8 кв-ийн цахилгаан үүсгүүрийн мотор 3 ширхэгийг тус тус өгч хөдөөгийн ард иргэдэд нийгмийн үйлчилгээ үзүүлэхэд томоохон дэмжлэг боллоо.

Сумын ИТХ-нь сумынхаа Засаг дарга түүний Тамгын газар, албадуудтай хамтран ажиллаж, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлийн биелэлт, төсвийн орлогын төлөвлөгөө, орон нутгийн орлого бүрдүүлэлт, төсвийн зарцуулалт, ОНХС, СХС зэрэг төсөв санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд нь байнгын хяналт тавьж ажилласны үр дүнд 2019 онд тус сумын орон нутгийн орлогын төлөвлөгөө бүрэн биелж, төсвийн бүх байгууллагууд өргүй гарсан байна.

Мөн сумын ИТХ-нь 2019 онд АНУ болон ОУ-ын хөрөнгө оруулалттай нутгийн иргэдийн оролцоотой байгаль хамгаалах, ТНС байгууллагатай хамтран ажиллаж хөдөөгийн 2 багт малчдын 13 нөхөрлөлийг үүсгэн байгуулж, Улаанбаатар, Хэнтий, Дорнод зэрэг аймгуудаар нөхөрлөлийн гишүүдийг аялуулан байгаль хамгаалах чиглэлийн сургалтуудыг 6 удаа зохион байгуулсан. Тухайн суманд ОУ-ын хүнсний стандарт хангасан бяслагны үйлдвэрийг 80 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар байгуулж, орон нутгаас үйлдвэрийн байрны асуудлыг шийдвэрлэн үйл ажиллагааг нь эхлүүлж, саалийн хугацаанд иргэдээс бэлэн мөнгөөр сүүг нь худалдан авч бэлэн мөнгөний эргэлтийг нэмэгдүүлэх, мөн нутгийн брэнд бүтээгдэхүүний тоог нэгээр нэмэгдүүлсэн оновчтой арга хэмжээ болсоны дээр Хөвсгөл аймгийн хэмжээнд анхдагч, улсын хэмжээнд хөдөө орон нутгийн 3 дахь үйлдвэр юм. ТНС байгууллага гэрээний дагуу 2017-2019 оны үйл ажиллагааны явцыг дүгнэн төсөл ОУ-ын хэмжээнд хангалттай ажилласан дүгнэлтийг авч тухайн суманд 2019-2021 оныг дуустал үргэлжлэн хэрэгжүүлж, хөдөөгийн 4 багийг бүрэн хамруулан үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллах боллоо.

АНУ-ын Монтана мужийн Их Сургуулийн багш, оюутнууд , “Уул ухаан” ТББ-тай хамтран хөрсний бүтэц, бэлчээрийн даац, бэлчээр дэх ургамлын нэр төрөл, ан амьтан түүний байршил усны судалгаа зэрэг бэлчээрийн мал аж ахуйтай холбоотой эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг 2020 оноос эхлэн явуулахаар гэрээ хэлцэл хийсэн байна.

Тус сумын ИТХ нь 2019 онд дэвшүүлсэн зорилтоо, батлагдсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулж 2019 оны 12 сарын 19-нд хуралдсан сумын ИТХ-ын ээлжит 15 дугаар хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхийн саналаар **93.8% А** үнэлэгдэж, мөн ЗДТГ-аас нутгийн иргэд, малчдын дунд явуулсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээр ИТХ-ын үйл ажиллагаа хангалттай сайн явагдаж байна гэсэн дүгнэлт гарсан нь ИТХ-ын үйл ажиллагаа олон нийтэд хүртээмжтэй, ил тод явагдаж байгааг харуулж байна.

Мөн ИТХ нь тухайн ажлын жилд аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, 2019 онд хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-ын хуралдаанаас баталсан үндсэн чиглэлийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж, өөрсдийн дэвшүүлсэн зорилтоо сумын Засаг дарга түүний Тамгын газар, орон нутагт төрийн үйлчилгээ үзүүлж буй бүх албадуудтай хамтран ажиллаж, дэвшүүлсэн зорилтоо амжилттай хэрэгжүүлээ.

ТАЙЛАН БИЧСЭН:

ИТХ-ЫН ДАРГА

..... /Д.НЯМДЭЛГЭР/

ИТХТ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

..... /Х.АДИЛМАА/

ХАВСРАЛТ